



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.07.28 № 274

танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох тус сумын Ардчилсан намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Ардчилсан нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817-1:2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817-8:2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

015030519

Дүгнэлт

Сумын Ардчилсан намын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль”-д оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр / ... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН



ШИНЭЛЭГ СУМ - ШИНЭ ХӨГЖИЛ

ХӨГЖЛИЙН
БОДЛОГО **2020**



**ХҮН БҮРД ОРЛОГО
ӨРХ БҮРД ӨСӨЛТ** ✓

АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020

ШИНЭЛЭГ СУМ, ШИНЭ ХӨГЖИЛ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛИЙН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт Ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх, эрх чөлөө, шударга ёс хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд Монгол хүн бүр хүсэл мөрөөдөлтэй, эрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, Ардчилсан Монгол Улсаа хөгжүүлэхийг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож,

1. Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах
2. Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглал
3. Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН АРДЧИЛСАН НАМ 2020-2024 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох “ШИНЭЛЭГ СУМ, ШИНЭ ХӨГЖИЛ” мөрийн хөтөлбөрөө Та бүхэндээ толилуулж байна.

УРИА: ХҮН БҮРД ОРЛОГО – ӨРХ БҮРД ӨСӨЛТ

НЭР: ШИНЭЛЭГ СУМ, ШИНЭ ХӨГЖИЛ



(Handwritten signature and mark)

ГАРЧИГ

НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

- 1.1. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БОЛОВСРОЛ
- 1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
- 1.3. ХҮН АМЫН ХӨГЖИЛ, ӨРХ ГЭР БҮЛ
- 1.4. АЖЛЫН БАЙР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
- 1.5. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ
- 1.6. СОЁЛ, УРЛАГ, СПОРТ

ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

- 2.1. ӨСӨЛТИЙН БОДЛОГО ЖИЖИГ ДУНД БИЗНЕС, БИЗНЕСИЙН ДАРХЛАА
- 2.2. ДЭД БҮТЭЦ
- 2.3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ
- 2.4. ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

ГУРАВ. ЭЗЭН МОНГОЛ

- 3.1. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, “ШИНЭ ХӨДӨӨ” ХӨТӨЛБӨР
- 3.2. “ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН” ХӨТӨЛБӨР
- 3.3. БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ
- 3.4. МАЛ АЖ АХУЙ
- 3.5. ГАЗАР ТАРИАЛАН

ДӨРӨВ. ХУУЛЬТАЙ МОНГОЛ

- 4.1. ИРГЭНДЭЭ ҮЙЛЧИЛДЭГ ЗАСАГЛАЛ

ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ

- 5.1. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ




НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

1.1. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БОЛОВСРОЛ

Хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн бүрийг эрдэм боловсрол төгс, хөдөлмөрч, бүтээлч сэтгэлгээтэй, эрүүл амьдралын хэв маягийг хэвшил болгосон, Өвөрхангай нутгийнхаа байгаль, түүх соёл, уламжлалаараа бахархсан өв тэгш хүмүүжлээр төлөвшүүлэн, хангалуун сайхан амьдрах эрхийг дээдэлсэн хувь хүний хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ. Нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.

1. Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, эх нутгийнхаа байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
2. Хүүхэд гэр бүл, цэцэрлэг, сургуулийн орчинд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, орчны эрүүл мэндийг сайжруулах бодлогыг нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиглэл болгоно.
3. Архинд донтолтын эсрэг архи согтууруулах ундаа хэрэглэдэггүй, эрүүл идэвхитэй амьдралын клуб байгуулахыг дэмжинэ.
4. Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх стандартыг хэрэгжүүлнэ.
5. Малчин өрхийн 6-8 настай хүүхдийг гэрээр сургах гэрийн сургалтын тогтолцоог хэрэгжүүлнэ.
6. Амжилттай хэрэгжиж буй “Мянган инженер” хөтөлбөрт орон нутгийн залуучуудыг хамруулна.
7. Соёлын төвийн үйлчилгээг сайжруулж хөдөөгийн багт бүрт урлаг соёлын үйлчилгээг хүргэх нөхцөл боломжоор хангаж, техник хэрэгсэлийг шинэчлэн, орчин үеийн техник хэрэгсэлээр бүрэн хангана.
8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, тэдний авьяас, хөдөлмөр бүтээлийг дэмжиж ажиллана.
9. Багш нарын мэдлэг, ур чадварыг тухай бүрд нь дээшлүүлж, давтан сургахад орон нутгийн төсвийн санхүүжилтээс дэмжлэг үзүүлэх ажлыг эхлүүлнэ.
10. Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн, тогтвортой, улс төрөөс хараат бус байх нөхцөлийг бүрдүүлж, удирдах албан тушаалтныг чөлөөлөх, томилох асуудалд сумын иргэдийн төлөөллөөс бүрдсэн “Боловсролын зөвлөл”-ийн саналыг харгалздаг болгоно.
11. Хүн ам, албан хаагч, ажилчдын цахим боловсролыг дээшлүүлж, бүх нийтийн цахим боловсролыг (Digital Literacy) дээшлүүлнэ.

1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ




1. Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулж, урьдчлан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
2. Сумын эрүүл мэндийн төвийн стандартыг хангуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
3. Хавдрын хөнгөвчлөх үйлчилгээ үзүүлэх өрөөтэй болно. Энэ чиглэлээр эмч нарыг давтан сургана.
4. Хүнийг өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог өрх гэрийн түвшинд тогтмол хийдэг эрүүл мэндийн үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгож, гэрийн эмчийн шинэ тогтолцоонд шилжүүлнэ.
5. Иргэн бүрийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулна.
6. Багийн эмч нарын мэргэжил, боловсролыг тутамд тасралтгүй дээшлүүлэхэд орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлнэ
7. Тэтгэвэр тогтоолгосон ахмад эмч нарыг эрүүл мэндийн төвд зөвлөхөөр ажиллуулахыг бодлогоор дэмжинэ.
8. Уламжлалт анагаах ухааны төвтэй болох ажлыг судалж хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

1.3. ХҮН АМЫН ХӨГЖИЛ, ӨРХ ГЭР БҮЛ

1. Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн өмнөх насны хүүхдийг хүмүүжүүлэх олон талт ажлыг зохион байгуулна.
2. Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
3. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг сайжруулна.
4. Хүүхдийг цахим мэдээллийн халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.
5. Иргэдэд зориулсан цахим боловсролын төвийн Насан туршийн боловсролын нэгжийг түшиглэн байгуулна.

1.4. АЖЛЫН БАЙР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийг сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.
2. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлтийн судалгааны чанарыг сайжруулж, хэрэгцээтэй байгаа ажил, мэргэжлийг эдийн засгийн салбар, ажил мэргэжлээр



нарийвчлан гаргаж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын элсэлттэй нягт уялдуулна.

3. Хүүхэд харах үйлчилгээг бий болгох замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
4. Гарааны бизнес буюу старт-апыг хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.

1.5. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

1. Ахмадын өдөр өнжүүлэх төвийг өргөжүүлж, байнгын ажиллагаатай болгоно. .
2. Малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.
3. Эх хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.


1.6. СОЁЛ, УРЛАГ, СПОРТ

1. Уламжлалт өв соёлоо бодлогоор дэмжин монгол хүнийг төлөвшүүлэхэд онцгойлон анхаарна.
2. Соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлан дэмжиж, үндэсний агуулгатай дэлхийн сонирхлыг татахуйц үнэ цэнтэй өвийг хөгжүүлнэ.
3. Түүх соёлын дурсгалт газрын хамгаалалтыг сайжруулж, соёлын өвийг хамгаалагч, харгалзагч нарын урамшууллыг нэмэгдүүлнэ.
4. Спортын улс, бүсийн хэмжээний уралдаан, тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ, улс бүс, олон улсын тэмцээнд оролцох баг тамирчдын зардал орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлдэг тогтолцоог бий болгоно.

ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

2.1. ӨСӨЛТИЙН БОДЛОГО ЖИЖИГ ДУНД БИЗНЕС, БИЗНЕСИЙН ДАРХЛАА

1. Сум хөгжүүлэх сангийн зээлийг иргэдэд тэгш хүртээмжтэй, ялгаварлалгүйгээр олгоно.
2. Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг жил бүр тогтвортойгоор нэмэгдүүлэн, үйл нутгийн Брэнд бүтээгдэхүүн бий болгоход СХС-ын бодлогоор дэмжинэ.
3. Ажиллах хүчийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр олноор бий болгохыг нэн тэргүүний зорилт гэж үзэн шинэ ажлын байрыг бий болгох бүтээн байгуулалт, бизнесийн төслүүдийг бүх талаар дэмжиж хөгжүүлнэ.
4. Төрийн албанаас бизнесийн салбарт шилжсэн баялаг бүтээгч иргэдийнхээ бизнес эрхлэлтийн, хөрөнгө оруулалтын анхны санхүүжилтийг бодлогоор дэмжинэ.



5. Төрийн албанаас эрт тэтгэвэртээ гарч жижиг дунд, бичил бизнесийн салбарт шилжин баялаг бүтээх иргэдээ эдийн засгийн бодлогоор дэмжинэ.
6. Эрдэс баялгийн, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнд, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн ажлын байрыг бий болгохыг дэмжинэ.
7. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд орон нутгийн аж ахуйн нэгж болон хувийн хэвшлийг давуу эрхтэй оролцуулахыг дэмжиж ажиллана.
8. Орон нутгийн аж ахуй нэгж, компаниудын чадавх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх төслүүдийг дэмжинэ. Мал аж ахуй, газар тариалан, гахай, тахиа, зөгийн аж ахуйд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загвар хөгжүүлэхийг дэмжинэ.
9. Иргэд, орон нутаг, олон нийтийн оролцоо, олон улсын байгууллагуудтай хамтран ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, байгаль орчныг нөхөн сэргээнэ.

2.2. ДЭД БҮТЭЦ


1. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинэ суурьшлын төлөвлөлтөнд эрчим хүч, цэвэр бохирын инженерийн шугам сүлжээг бий болгох ажлыг эхлүүлнэ.
2. Үүрэн телефоны бүх сүлжээний өргөтгөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
3. Стандартад нийцсэн камерын системтэй болгоно.
4. Гэр хорооллын гудамжийг цэгцэлж, жишиг гудамжууд бий болгоно.
5. А зэрэглэлийн бүсэд дахин төлөвлөлтийг хийж, “Хаус хороолол” төслийг хэрэгжүүлэн орчин үеийн загвар төлөвлөлт бүхий хаус хороололтой болох ажлыг эхлүүлнэ.

2.3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

1. Орон нутгийн онцлогт нийцсэн аялал жуулчлалын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

2.4. ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

1. Хүн амын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг чанартай хүнсээр хүртээмжтэй хангаж, дотоод зах зээл дэх хүнсний нийлүүлэлтийн сүлжээнд аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлнэ.
2. Жимс, жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэгцээг дотооддоо хангахад чиглэгдсэн хувийн хэвшлийн санаачилгыг дэмжин хэрэгжүүлнэ.
3. Орон нутгийн иргэдийн хүнсний хэрэгцээгээ өөрөө хангах, хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг бүх талаар дэмжинэ.



4. Дөрвөн улирлын хүлэмжийн төсөл хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.
5. Төмс, хүнсний ногооны төрөлжсөн зорь барих ажлыг дэмжинэ.

ГУРАВ. ЭЗЭН МОНГОЛ

3.1. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, ШИНЭ ХӨДӨӨ” ХӨТӨЛБӨР

1. Бэлчээрийн менежментийг сайжруулна.
2. Бэлчээрийн болон хүн амын усан хангамжийг сайжруулна
3. Хог хаягдлын менежментийг сайжруулна.
4. “Шинэ баг”-төсөл хэрэгжүүлнэ.

3.2. “ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН” ХӨТӨЛБӨР

1. Мал аж ахуйн салбарыг эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн шинэ технологи, инновацад суурилж, хөгжүүлэн мэдлэг бүхий малчдыг малчин бизнесмен болгох замаар тогтвортой орлого бүхий хүчтэй дундаж давхаргыг тэлэх бодлого хэрэгжүүлнэ.
2. Иргэдийн санаачилгад суурилсан “Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.3. БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ


1. Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.
2. Бэлчээр хамгаалах зорилгоор мэрэгч болон байгаль орчинд сөрөг нөлөө ихтэй хортон шавьжыг устгана.

3.4. МАЛ АЖ АХУЙ

1. Малыг тооноос илүү чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг бодлогоор дэмжинэ.
2. “Хариуцлагатай нүүдэлчид” хөтөлбөрийн хүрээнд малын гаралтай түүхий эдийг мөшгөх тогтолцоог бүрдүүлнэ.
3. Махыг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулж, малыг вакцин, туулгад бүрэн хамруулан эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлнэ.
4. Хөдөөгийн малчин өрхийг дэмжин “Малжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.
5. Гахай, шувууны аж ахуй эрхлэх, хөгжүүлэх санаачилгыг дэмжинэ.

3.5. ГАЗАР ТАРИАЛАН

1. Малыг тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бодлогоор дэмжинэ.
2. Орон нутгийн онцлогт тохирсон газар тариалангийн бодлогын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.



Handwritten signature and initials in black ink.

ДӨРӨВ. ХУУЛЬТАЙ МОНГОЛ

4.1. ИРГЭНДЭЭ ҮЙЛЧИЛДЭГ ЗАСАГЛАЛ

1. Нас, хүйс, хөгжлийн ялгаа, гэх мэт аливаа төрлийн ялгаварлал, дарамт, хүчирхийллийг ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн үе шаттай арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.
2. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах, ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.
3. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж уулзах боломжгүй иргэд төрийн захиргааны албан тушаалтан, албан хаагчидтай онлайнаар уулзах боломжийг бүрдүүлнэ.
4. Төрийн байгууллагаас гаргах шийдвэрт ард иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний шийдвэрийг шилэн болгож ажиллана.
5. Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэж ажиллана.
6. Төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
7. Иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлнэ.
8. Төрөөс зохион байгуулах аливаа төсөл, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтэд ил тод нээлттэй болгоно.

ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ

5.1. ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ

1. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах төв байгуулна.
2. Хөв цөөрөм байгуулах боломж, нөхцөлийг судлана.
3. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэргээр цогц үйл ажиллагааг шат дараалан авч хэрэгжүүлнэ. “Эко сум” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
4. Орчноо ногооруулсан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулна.

